

САНАЛ АСУУЛГАТАЙ МОНГОЛ НААДАМ



Лос Анжелес орчмын Монголчууд олон түүхт ойнууд давхацсан Үндэсний Их Баяр Наадмаа шинэ газар ёслол, хүндэтгэл төгөлдөр сайхан тэмдэглэлээ. Наадмын талбайд олон содон үйл ажиллагаа болсны нэг нь **Цөмийн аюулын Эсрэг Монголын Хөдөлгөөнөөс** анх удаа санаачлан явуулсан **санал асуулга, мэдээлэл түгээх, хүмүүсийн санал бодлыг сонсох** зэрэг ажлууд байлаа.

Санал асуулгын үр дүн

Нийт **400** орчим наадамчдаас насанд хүрсэн **218** хүний саналыг авахад, **211** хүчинтэй саналын хуудас гарсан. Санал асуулгын **3** асуултанд хүмүүс дараах байдлаар хариулжээ.

д/д	асуулт	хариулт		
		Тийм	Үгүй	хариулаагүй
1.	Та Монголын газар нутагаас гадаадынханд зарах, түрээслэхийг дэмжиж байна уу?	2	208	1
2.	Та Монгол Улс уран олборлох, атомын цахилгаан станц барихыг дэмжиж байна уу?	25	184	2
3.	Та Монголд гадаад, дотоодын цөмийн хаягдлыг булшлахыг зөвшөөрч байна уу?	0	211	0

Юу хийвэл зохилтой талаар хүмүүс санал бодлоо дараах байдлаар илэрхийлсэн.

Иргэн **О.** -Монгол хурдны зам, хүүхдийн төлөө парк барьж бас утаанаасаа салах хэрэгтэй.

Иргэн **Ч.** - Монголын газар нутаг Монгол улсын ард түмний өмч учир хэзээ ч гадаадын хүмүүст өмчлүүлж болохгүй. Эх оронч үзлийг хүн бүр үр хүүхэддээ зааж сургах нь чухал байна.

Иргэн **Ц.** -Улс эх орноо ногоон бүс болгоё! Хөдөө аж ахуйгаа хөгжүүлж, мал сүргээ эрчимжүүле!

Хувийн дүгнэлт

1. Хариултаас харахад газар нутагаа зарахыг дэмжсэн, хүн гараагүй. Харин түрээслэхийг дэмжсэн хүн 2 байна. Сүүлийн үед Монголчуудын дунд **“Эзэнгүй зэлүүд газараа өөр улсад 99 жилээр түрээслээд ахиухан мөнгө олъя”** гэсэн ойворгон үгс хаа сайгүй яригддаг болов. Түрээсэлсэн газарт томоохон “хот улс” бий болж, тэнд харь үндэсний хүмүүс хэдэн үеэрээ амьдран сууж, хэт олшрон Монголын хүн амын олонхи болж бидний Монголчууд эх нутагтаа цөөнхид тооцогдон Монгол гэдэг үндэстэн улс байхгүй болох аюул нүүрлэх вий.
2. Уран олборлох, Атомын Цахилгаан Станц барихыг нилээд буюу 25 хүн дэмжжээ. Энэ нь “атомын цахилгаан станц хамгийн цэвэр технологи” гэсэн тархи угаалтын тусгал болвуу. Уран боловсруулах, атомын цахилгаан станц ажиллуулах зэрэг үйлдвэрлэлийн шат дамжлага бүрт байнга хорт хаягдал гарч түүнийг аюулгүй хадгалах асуудал “толгойны өвчин” болдог, түр хадгалж байх зуур цацраг нь орчноо хордуулсаар байдаг ба өнөөг хүртэл хүн төрөлхтөн урт хугацаанд найдвартай хадгалах арга зам олоогүй байна. Энэ тухай дэлгэрэнгүй мэдээллийг www.golomt.org –оос авч цөмийн эрчим хүчний “жинхэнэ өртөг”-ийг олж мэднэ үү. Эрчим хүчнийхээ 4-хөн хувийг гаднаас авдаг, нүүрсний болон нар, салхины арвин нөөцтэй манай улсын хувьд эдийн засгийн хувьд үр ашиггүй, хэт өндөр өртөгтэй, эрсдэлтэй АЦС барих ямар ч шаардлага байхгүй.
3. Цөмийн хаягдал булшлахыг санал асуулгад оролцсон хүмүүс дуу нэгтэйгээр 100 хувь эсэргүүцсэнд энэхүү санал асуулгын **үнэ цэнэ, ач холбогдол** оршино. Асуудал ч өөрөө тусгаар тогтнолын үнэ цэнэтэй юм.
4. Санал асуулгад оролцсон хүмүүсийн зүгээс газар зарах ба түрээслэх, уран олборлох ба АЦС барих, гадаад ба дотоодын цөмийн хаягдал гэх мэт 2 өөр асуудлыг 1 асуултанд багтаасан нь хариулахад төвөгтэй байсан тухай санал, шүүмжлэл хэлж байлаа. Эдгээр нь өөр хоорондоо зарчимын ялгаатай ойлголтууд боловч газар нутгийн маргаан, өмчлөх, сонгох гээд хүний эрхийн наад захын асуудлууд, олборлосон ч, ашигласан ч хордох эрсдэл гадаад дотоод ялгалгүй цацрагт хордох, үр удмаараа айдас түгшүүртэй амьдрах зэрэг үр дагавар, уршиг яршиг нь адилхан тул зориуд нэг дор хийсэн болно. Гэхдээ хойшид үүнийг анхаарч ажиллая.
5. Манай ардчилсан ерөнхийлөгч, арваад сайд, эрхэм 76 тэрүүхэн тэндээ нам нийлж, сэм шийдэж арай боломгүй, хамрах хүрээ, үзүүлэх нөлөө нь үлэмж хэтийдсэн, томоохон асуудлуудыг энэ мэтээр **ард иргэдээсээ асуугаад хийчихэд юу нь болохгүй, юу нь хэцүү байна?!**

Гагцхүү тэдэнд **ардаа гэх үнэн сэтгэл, алсаа харах холч ухаан** дутааж байх шиг.

“Ард түмний санал асуулгын тухай хууль” хэрэглэгдэхгүй, хэрэгжихгүй байсаар өлгийдөө өтөллөө.

Гаргасан зардал

Энэхүү санал асуулгыг явуулахад зориулж Мөнхтөр тараах материал, гарын авлага, үзүүлэнгийн материалыг хар,цагаан болон өнгөтөөр хэвлүүлэх, бичгийн цаас, үзүүлэн хийх хөөсөн хавтан, хэвлэгчийн хор, бичгийн хавтас худалдан авах зэрэгт **\$178,22 картаар**, 2ш уриа хэвлүүлэхэд **\$60,00** мөн 10ш подвоолк авахад **\$25**, машины зогсоолд **\$5,00** доллар нийт **\$268,22** доллар, Төрбурам шүршдэг будаг авахад **\$6,00** доллар **бэлэнээр** тус тус хувиасаа зарцуулав. Үүнд нааш цааш явсан шатахууны зардлыг оруулсангүй. Түүнчлэн Хуягаа ах **\$20,00**, Сүхээ **\$20,00**, Аюур **\$10,00** доллар тус тус хандивласан.



STAPLES
that was easy.
Low prices. Every item. Every day.
1610 Wilshire Boulevard
SANTA MONICA, CA 90409

QTY	SKU	PRICE
REWARDS NUMBER 5950451319		
6	FOAM BOARD 30X40 B 718103147170	6.990ea 41.94
200	101-250 BW2 LTR ST 713954	0.175ea 35.00
	Your Rewards Price \$0.157	-3.60
1	SPLS 8.5X11 50XREC 718103100977	10.49
SUBTOTAL		83.83
Standard Tax 9.25%		7.75
TOTAL		\$91.58

Debit Tender:
Card No.: XXXXXXXXXXXX7839 [S] **91.58**
Auth No.: 001922



STAPLES
that was easy.
Low prices. Every item. Every day.

QTY	SKU	PRICE
REWARDS NUMBER 5950451319		
1	HP 74/75 BLK/CLR I 883585179497	31.99
4	INK RECYCLING LIMIT 725137	0.010ea 0.00
	Instant Savings #20705 <-0.04>	9.99
1	SMALL BLK HARDSHEL 681066411872	41.98
SUBTOTAL		41.98
Standard Tax 8.75%		3.67
TOTAL		\$45.65

Debit Tender:
Card No.: XXXXXXXXXXXX3871 [S] **45.65**
Auth No.: 419579



STAPLES
that was easy.
Low prices. Every item. Every day.

QTY	SKU	PRICE
REWARDS NUMBER 5950451319		
68	1-100 BW LTR STD 713893	0.100ea 6.80
	Price Override 10.00%	-0.88
68	51-100 CLR PREM 429796	0.590ea 40.12
	Price Override 10.00%	-4.01
SUBTOTAL		44.03
Standard Tax 8.75%		3.85
TOTAL		\$47.88

Debit Tender:
Card No.: XXXXXXXXXXXX7839 [S] **47.88**
Auth No.: 074816

TOTAL ITEMS 156



OGS BROTHERS
IMPORTER AND WHOLESALE
www.ogsbrothers.com

1300 S. Main St. #5
Los Angeles, CA 90015
Email: ogsbrothers@yahoo.com

Tel: 213.745.6655
Cell: 626.417.8601
Cell: 626.407.8187
Fax: 213.742.6657



117 E. 7th ST.
LOS ANGELES, CA 90014

043685

THIS CONTRACT LIMITS OUR LIABILITY-READ IT
LOCK YOUR CAR

This ticket licenses the holder to park one automobile in this area. PARK AS DIRECTED BY ATTENDANT. The management hereby declares itself not responsible for fire, theft, damage or loss of car or any article left in same, all of such risk being assumed by licensee. Only a rental of space license is granted hereby and no bailment is intended or granted. THIS LICENSE SHALL END AT MIDNIGHT OF THE DAY UPON WHICH THE LICENSE IS ISSUED.

AUTOMATE PARKING, INC.
(310) 674-3386




Walmart
Save money. Live better.


Walmart
MANAGER SYNTRIA PETERSEN
(323) 299-8014
BALDWIN HILLS, CA

ST# 2960	DPS# 00004066	TEB# 09	TR# 04097
5STAR COMP	004310009120		4.42 X
PADLOCK	003920897623		4.77 X
5STAR COMP	004310009120		4.44 X
POLY FILE	007431965109		4.44 X
FILE BOX	076201644131		4.44 X
TAN GRAZED	072700112181		97.00 X



KB SIGN INC.
www.kbjsign.com / kbjsign@gmail.com
YOUR 1-STOP SIGN SHOP FOR ALL YOUR SIGNAGE NEEDS



\$60.- cash air paid
KBJ Sign. 

Бэлнээр хийсэн төлбөрт мөнгөний баримт байхгүй тул харилцах хаягуудыг тавив.

Талархал

Бэлтгэл ажилд санаа оноогоо нэмэрлэж, үнэтэй зөвлөгөө өгсөн Ширчин, facebook-ийн анд Хэрлэн, тараах материалын эх бэлтгэж, шаардлагатай бүх мэдээлэлээр хангасан Амарлин, хэвлэж бэлдсэн Оюунаа, Бооби, нугалбар хийсэн Ганаа эгч, түүний охин нь найзуудтайгаа, гэрэл зургийн болон дүрс бичлэгийн сурвалжлага хийсэн Ариунаа, бичлэгийг эвлүүлж найруулсан Золоо, шөнөжин сууж подвоолконы эх загвар хийж, санал асуулгыг эхнээс нь дуустал хамт зүтгэсэн Төрбурам нарын зэрэг үнэт цагаа харамгүй зарж, алжаалыг умартан ажилласан нөхөддөө, мөнгөн хандив өргөсөн бүх хүмүүстээ баярлалаа!

Зүрх сэтгэлийнхээ дуудлагаар бидний үйл хэргийг дэмжин, баярлах цэнгэх цагаа харамгүй заран саналаа өгч, үзэл бодлоо хэлж, дэмжин оролцсон LA -ийн Монголчуудынхаа иргэний идэвхийг бахдахгүй байхын аргагүй!

Та бүхний иргэний зориг, идэвхи санаачилгыг үнэлж, хожмын өдөр цөмийн аюулгүй Монгол бахархан дурсах болтугай!

Жич: Уг ажлыг зохион явуулахад цаг хугацааны хувьд давчуу, хүн хүчний нөөц боломж хомс байснаас хүн нэг бүрээс санал авч чадаагүйг хэлэх нь зүйтэй байх.

Та бүхэн санал асуулгын зургуудыг эндээс үзнэ үү: <http://s796.photobucket.com/albums/yy245/khagaan/>

Видеог эндээс үзнэ үү: <http://vimeo.com/26792573>

Facebook хаяг: **ANTI NUCLEAR MOVEMENT MONGOLIA**

Мэдээдэл авах суваг: www.golomt.org

мэдээг бэлтгэсэн: зураач Мөнхтөр

Los Angeles 07/24/2011